



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 4/342

Мандатговь

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 176 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 19 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 06.00 цагаас 2021 оны 08 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд сунгасугай.

2. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг диско баар, цахим тоглоом болон хүүхдийн тоглоомын газар, үзэсгэлэн худалдаа, хурим найр, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн зохион байгуулахыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд, хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 08:00 цагаас 21:00 цагийн хооронд ажиллахаар тогтоож, сумын Онцгой комиссын шуурхай штабын даргатай хариуцлагын гэрээ байгуулж ажиллахыг, аж ахуйн нэгжийн захирал, эрхлэгч нарт, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр өнгөрүүлэхээр, аймгийн төврүү нэвтрэх тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнийг 00.00 цагаас

481210244

08.00 цагийн хооронд нэвтрүүлэхгүй байхаар зохицуулж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

5. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрснээс бусад иргэдийг төлбөртэй түргэвчилсэн шинжилгээнд хамруулж, шаардлагатай тохиолдолд гэрийн ажиглалтад 7 хоног шилжүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Тус хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гарахгүй байх, олон нийтийн газраар явахдаа маск зүүх, зай барих, гараа ариутгах, мэргэжлийн байгууллага, алба хаагчдаас тавьж буй заавар зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ